



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/238

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт, төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 22 ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, үүссэн өр төлбөр барагдуулах, нөөцөд байгаа өвс тэжээлийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зориулалтаар батлагдсан 75,000,000 (далан таван сая) төгрөгийг зарцуулах жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3. Төлөвлөгдсөн бараа, ажил, үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар) -т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгийн газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
07 дугаар сарын 22 өдрийн А/238 дугаар
захирамжийн хавсралт

№	Зардлын утга	Нийт үнэ
1	Хөвсгөл Жугнай ХХК-д "Шинэ-Хөдөө" төслийн өвс, тэжээлийн өр	22,561,160
2	Аймгийн Мал хамгаалах сангаас Тариалан суманд өсгөн үржүүлж байгаа Сэлэнгэ үхрийн цөм сүрэгт өгсөн өвсний үнэ	7,144,764
3	Аймгийн мал хамгаалах сангийн өвс, тэжээлийн хадгалалтыг сайжруулах зардалд	15,000,000
4	2022-2023 онын өвөлжилтийн бэлгэл хангах зорилгоор хүчид тэжээл худалдан авах	30,294,076
	НИЙТ	75,000,000